



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)

СОГТУУГААР ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДСОН ЖОЛООЧИД НОГДУУЛСАН ШИЙТГЭЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТУХАЙ

Жолооч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон байсан ч түүнд ногдуулсан шийтгэлийг хүчингүй болгож болно. Жишээлбэл цагдаагийн албан хаагчид жолоочийн согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах үед эсвэл түүнд эрүүл мэндийн үзлэгт хамрагдах чиглэл өгөх явцад гэрч ч байгаагүй, видео бичлэг ч хийгээгүй тохиолдолд: Тухайлбал дараах хэрэг дээр нотлох баримтыг зөв үнэлэх нь ямар чухал болохыг ОХУ-ын Дээд шүүх сануулсан байна.

Хэргийн дугаар: № 32-ЗХ 19-3

Өргөдөл гаргагч: Иван Иванов

Маргааны үндэслэл: ОХУ-ын “Захиргааны зөрчлийн тухай хуулийн” 12.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан захиргааны зөрчлийг давж заалдах нь

Шийдвэр: өмнө гарсан шийдвэрүүдийг хүчингүй болгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох.

Замын цагдаагийн албан хаагчид автомашиныг зогсоож, түүний жолооч болох Иван Ивановыг согтууруулах ундаа уусан эсэхийг шалгах тестийн хоолой руу нь үлээхийг хүсэв. Тус тестийг үлээсэн амьсгалаас согтууруулах ундааг илрүүлсэн тул цагдаагийн албан хаагчид захиргааны зөрчлийн тухай тэмдэглэл болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах тухай тэмдэглэл үйлджээ.

Хуульд заасны дагуу согтууруулах ундааг хэрэглэсэн эсэхийг шалгах, эмнэлгийн үзлэгт оруулах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах ажиллагааг хоёр гэрчийг байлцуулан эсвэл видео бичлэг хийж үйлдсэнийг тэмдэглэл эсвэл шинжилгээний дүгнэлтэд хавсаргадаг (ОХУ-ын “Захиргааны зөрчлийн тухай хуулийн” 25.7 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, 27.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг). Ивановын хэргийн материалд видео бичлэг хийснийг дурдсан боловч тус видео бичлэг байгаагүй. Гэрч ч байгаагүй.

Шүүх дээр Иванов өөрийгөө тус хэрэг болох үед согтуу байгаагүйгээ болон замын цагдаагийн албан хаагчдын дарамт шахалтаар бүх бичиг баримтад гарын үсгээ зурсан гэдгээ мэдэгдсэн байна. Гэвч Саратов мужийн Саратов дүүргийн 2-р анхан шатны шүүхийн шүүгч Ивановыг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэм буруутайд тооцож, 30 мянган рубль



торгууль ногдуулж, 1.5 жилийн хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хассан (ОХУ-ын “Захиргааны зөрчлийн тухай хуулийн” 12.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) байна.

Тус шийдвэрийг Иванов хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд Саратов мужийн Саратов дүүргийн давж заалдах шатны шүүхэд ханджээ.

Саратов мужийн Саратов дүүргийн давж заалдах шатны шүүгч, шүүх хуралдааны явцад согтууруулах ундааг хэрэглэсэн эсэхийг шалгах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах ажиллагааг явуулах үед хийсэн видео бичлэгийг асуусан боловч ОХУ-ын Дотоод хэргийн яамны Саратовск дахь хот хоорондын хэлтсийн дарга үүнийг өгөх боломжгүй гэж мэдэгдэв. Гэсэн хэдий ч үүнийг үл харгалзан, давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, шийдвэрлэсэн байна.

Тус хэрэг Улсын Дээд шүүхэд хүрэх үед, Улсын Дээд шүүх: Ивановын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасах, түүнчлэн согтууруулах ундааг хэрэглэсэн эсэхийг шалгах ажиллагаа нь ОХУ-ын “Захиргааны зөрчлийн тухай хуульд” зааснаар хоёр гэрчийг байлцуулан эсвэл видео бичлэг хийж үйлдсэнийг тэмдэглэл эсвэл шинжилгээний дүгнэлтэд хавсаргаагүй, хууль зөрчиж үйлдэгдсэн тул хүлээн зөвшөөрөх боломжгүй нотлох баримт гэж тооцно (ОХУ-ын “Захиргааны зөрчлийн тухай хуулийн” 25.7, 27.12, 27.12.1. дүгээр зүйл¹). Мөн ОХУ-ын “Захиргааны зөрчлийн тухай хууль” өмнөх шүүхийн шийдвэрүүд хүчин төгөлдөр болсон тохиолдолд хэргийн материалыг замын цагдаагийн газарт буцааж өгөх замаар зөрчлийг арилгахыг зөвшөөрдөггүй. Иймд Улсын Дээд шүүх тус хэргийн үйл явцыг нотлох хуульд заасан баримтгүй учир анхан шатны шийдвэр, давж заалдах шатны магадлалыг хүчингүй болгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох шийдвэр гаргажээ (№ 32-ЗХ 19-3)².

¹ "Кодекс Российской Федерации об административных правонарушениях" от 30.12.2001 N 195-ФЗ// (ОХУ-ын 2001 оны 12 сарын 30-ны өдрийн “Захиргааны зөрчлийн тухай хууль”) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/

² Постановление Верховного суда РФ от 05 марта 2019 года №32-АД 19-3 // (ОХУ-ын Дээд шүүхийн 2019 оны 3-р сарын 05-ны өдрийн 32-ЗХ 19-3 тоот тогтоол) URL: http://vsrf.ru/stor_pdf.php?id=1744710



Анхааруулга: ОХУ-ын 2006 оны 7-р сарын 27-ны өдрийн № 152 "Хувийн мэдээллийн тухай" хуулийн 7 дугаар зүйлд "Хувийн мэдээлэлд нэвтрэх эрхтэй операторууд болон бусад этгээдүүд ОХУ-ын хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр түүний хувийн мэдээллийг гуравдагч этгээдүүдэд задруулахгүй, бусдад тараахгүй байх үүрэгтэй"³ гэж зааснаар тус шийдвэрийг орчуулахдаа хүний нэрийг өөрчилж бичсэн болно.

Орчуулсан: С. Жансая
Шүүхийн сургалт, судалгаа,
мэдээллийн хүрээлэнгийн
Үндсэн хууль, олон улсын эрх зүйн
судлаач

³ ст. 7 Федерального закона "О персональных данных" от 27.07.2006 N 152-ФЗ (последняя редакция)// (ОХУ-ын 2006 оны 7-р сарын 27-ны өдрийн № 152 "Хувийн мэдээллийн тухай" хуулийн 7 дугаар зүйл)
URL:http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_61801/a15bab6050028753706f22c32fe60627a7be79f9/